



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 11 сарын 09 өдөр

Дугаар 18/303

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Өндөр хурдны интернетийн үйлчилгээ /бүх алба, салбар/” үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны
дарга:

Ц.Ган-Эрдэнэ

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Мэдээлэл аюулгүй байдал, технологийн албаны Программ хангамж хөгжүүлэлтийн хэсгийн дарга)

Гишүүд:

Б.Дөлгөөн

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Хамтын ажиллагааны газрын гадаад харилцааны мэргэжилтэн)

Ц.Цэрэндаш

(Үндэсний аж үйлдвэрлэлийн зөвлөлийн гишүүн
(тохиролцсоноор)

Б.Мэндсайхан

(“ХУД Яармаг” Төрийн бус байгууллагын гишүүн
(тохиролцсоноор)

Нарийн бичгийн
дарга:

Б.Сумъяажав

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө оруулалт, захиалагчийн албаны Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн)

17120 1669

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо (Ц.Ган-Эрдэнэ)-нд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал), Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендер нээхэд үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Сумьяажав)-д даалгасугай.

ДАРГА



С.МӨНХНАСАН